



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

“Монре даатгал” ХХК-д дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч У.Сийлэнгээс 294,540,000 /хоёр зуун ерэн дөрвөн сая таван зуун дөчин мянган/ төгрөг, хувь нийлүүлэгч Р.Туяацэцэгээс 205,460,000 /хоёр зуун таван сая дөрвөн зуун жаран мянган/ төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

| | Хувь нийлүүлэгч | Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/ | | | Дүрмийн санд эзлэх хувь |
|----|-----------------|------------------------------|-------------------------|-----------------|-------------------------|
| | | Эхний үлдэгдэл | Нэмэлт хөрөнгө оруулалт | Эцсийн үлдэгдэл | |
| 1. | У.Сийлэн | 538,000,000 | 294,540,000 | 832,540,000 | 55,5 хувь |
| 2. | Р.Туяацэцэг | 262,000,000 | 205,460,000 | 467,460,000 | 31,17 хувь |
| 3. | П.Ганзориг | 200,000,000 | - | 200,000,000 | 13,33 хувь |
| | Дун | 1,000,000,000.0 | 500,000,000 | 1,500,000,000.0 | 100 хувь |

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Монре даатгал” ХХК /П.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН